

ЧАНАР - БИДНИЙ ЗОРИЛТ

СТАНДАРТ, ХЭМЖИЛЭЛЭЙ

СТАНДАРТ, ХЭМЖИЛЭЛЭЙН ГАЗРЫН ХЭВЛЭЛ /2019 ОН №02/

ХАНГАМЖИЙН СҮЛЖЭЭНИЙ ҮР ӨГӨӨЖИЙГ
НЭМЭГДҮҮЛЭХЭД ИТГЭМЖЛЭЛИЙН ҮҮРЭГ



ДЭЛХИЙН ИТГЭМЖЛЭЛИЙН ӨДӨР

2019.06.09

WWW.MASM.GOV.MN





ЧАНАР - БИДНИЙ ЗОРИЛТ

СТАНДАРТ, ХЭМЖИЛЗҮЙ

СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ

Сэтгүүлийн эрхлэгч:

Б.Эрдэнэзул

Нарийн бичгийн дарга:

Д.Мөнхжин

Гишүүд:

Д.Бэхбат
Д.Өнөрбилэг
З.Мөнхбат
Г.Батзориг
В.Ганзориг
Б.Гантулга

Техник редактор:

Б.Дөлгөөнбаяр

© Энэхүү сэтгүүл нь Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулиар хамгаалагдсан болно.

Сэтгүүлийн захиалга:

"Монгол шуудан" ТӨХК Индекс – 200325

Сэтгүүлийн гаралт:

Улирал тутам



www.masm.gov.mn

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР

Энхтайвны гудамж – 46а
Улаанбаатар хот 13343
Утас: 976-51-263971
Факс: 976-51-261631
E-mail: standard@masm.gov.mn
press@masm.gov.mn
www.masm.gov.mn

АГУУЛГА

МЭНДЧИЛГЭЭ

- Хамтарсан мэдэгдэл
- Итгэмжлэлийн газрын даргын ярилцлага

ТАНИН МЭДЭХҮЙ

- Хангамжийн сүлжээний үр өгөөжийг нэмэгдүүлэхэд итгэмжлэлийн үүрэг
- Бэлчээрийн монгол малын махны экспортыг нэмэгдүүлэхэд тавигдах гол шаардлага
- Малын эм бэлдмэл, дааврын хэрэглээ, түүний эерэг ба сөрөг үр дагавар
- Монгол Улс дахь ургамал хамгааллын бодисын хэрэглээ, тулгамдаж буй асуудал

МЭДЭЭ

- Морь унаач хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавих шаардлага. MNS 6264:2018 стандартыг шинэчлэн баталлаа
- Монгол Улсын төрийн далбаа, ерөнхий шаардлага. MNS 6262:2011 стандартад нэмэлт өөрчлөлт орууллаа





ХАМТАРСАН МЭДЭГДЭЛ

ДЭЛХИЙН ИТГЭМЖЛЭЛИЙН ӨДӨР-2019 ХАНГАМЖИЙН СҮЛЖЭЭНИЙ ҮР ӨГӨӨЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХЭД ИТГЭМЖЛЭЛИЙН ҮҮРЭГ



IAF-ийн дарга
Шиао Жин Хуа



ILAC-ын дарга
Этти Феллер

2019 оны Дэлхийн итгэмжлэлийн өдрийг “Хангамжийн сүлжээний үр өгөөжийг нэмэгдүүлэхэд итгэмжлэлийн үүрэг” уриан дор тэмдэглэн өнгөрүүлэхээр онцлон дурдсан.

Хангамжийн сүлжээ нь хэрэглэгч, бизнес эрхлэгчдэд бүтээгдэхүүн, үйлчилгээг цаг тухайд нь өндөр үр ашигтай, чанартай хүргэхэд чухал үүрэгтэй.

Олон талт хил дамнасан, төрөл бүрийн хангамжийн сүлжээ шинээр бий болон хөгжиж байна. Эдгээр нь тогтвортой бөгөөд хариуцлагатай гэдгийг батлахын тулд оролцогч бүх талуудын шаардлагад нийцүүлсэн байна.

Итгэмжлэл, түүнтэй хамт чанарын дэд бүтэц болох стандарт, хэмжилзүй, тохирлын үнэлгээ зэрэг хүлээн зөвшөөрөгдсөн арга хэрэгслийг ашиглан хангамжийн сүлжээний үр өгөөжийг нэмэгдүүлдэг. Эдгээр арга хэрэгслүүд нь итгэлцэл, баталгааг бий болгоход дэмжлэг үзүүлдэг бөгөөд эцсийн бүтээгдэхүүн, үйлчилгээний найдвартай байдлыг хангаж, тэдгээрийг зах зээлд нийлүүлэх, ашиглах боломжийг олгодог.

Хүүхдийн тоглоомын аюулгүй байдлын сорилт гүйцэтгэдэг лабораторийн итгэмжлэлээс үйлдвэрлэлийн үйл явцын хяналт, хүнс үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь аюулгүй байдлын стандартад нийцсэнийг нь итгэмжлэлээр дамжуулан баталгаажуулж, сонирхогч талуудын өргөн хэрэглээг хангаснаар хангамжийн сүлжээн дэх үр өгөөж нэмэгддэг.

Олон улсын хил дамнасан хангамжийн сүлжээ нь дэлхий нийтэд итгэмжлэлийн үр шимийг хүртэгчдэд чухал ач холбогдолтой юм. Олон улсын итгэмжлэлийн форум (IAF) болон Олон улсын лаборатори итгэмжлэлийн хамтын ажиллагаа (ILAC) нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу итгэмжлэлийн үйл ажиллагааг явуулдаг.

Лаборатори, хяналтын байгууллага, баталгаажуулалтын байгууллага нь олон улсын стандартын шаардлагыг хангаж, итгэмжлэгдсэн байдаг. Тохирлын үнэлгээний байгууллагууд нь бүтээгдэхүүн, үйлчилгээ, тогтолцоо болон ажилтанд тогтоосон шаардлагад нийцсэн эсэх талаар тохирлын үнэлгээг явуулахдаа олон улсын стандартыг мөрддөг.

Дэлхий нийтэд энэхүү итгэмжлэлийн тогтолцоо бий болсноор хангамжийн сүлжээний салаа бүрт бизнес эрхлэгчид бүтээгдэхүүн, үйлчилгээгээ хүргэх, ялангуяа, хэрэглэгчдэд итгэлийг бий болгоход тусалдаг байна.



ИТГЭМЖЛЭЛИЙН ГАЗРЫН ДАРГА С.ГАНЦЭЦЭГ:

ХАНГАМЖИЙН СҮЛЖЭЭНИЙ ҮР ӨГӨӨЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХЭД ИТГЭМЖЛЭЛ ЧУХАЛ ҮҮРЭГТЭЙ

Сайн байна уу? Танд энэ өдрийн мэнд хүргэе. 2019 оны Дэлхийн Итгэмжлэлийн өдрийн уриа болоод ач холбогдлын талаар манай уншигчдад мэдээлэл өгөхгүй юу?

Өдрийн мэнд хүргэе. Тэгэлгүй яахав. Олон улсын итгэмжлэлийн Форум (IAF), Олон улсын лаборатори итгэмжлэлийн хамтын ажиллагааны байгууллага (ILAC)-аас хамтран санаачилсны дагуу жил бүрийн 6 дугаар сарын 9-ний “Дэлхийн итгэмжлэлийн өдөр”-ийг 11 дэх жилдээ тэмдэглэх болно. IAF-ILAC-аас жил бүр тодорхой нэг сэдвийг дэвшүүлдэг уламжлалтай бөгөөд энэ жилийн тухайд “Хангамжийн сүлжээний үр өгөөжийг нэмэгдүүлэхэд итгэмжлэлийн үүрэг” уриаг дэвшүүлжээ. Үүний зорилго нь хангамжийн сүлжээг дэмжин, тогтвортой хөгжлийг хангахад чанарын дэд бүтцийн арга хэрэгслүүд болох стандарт, хэмжилзүй, тохирлын үнэлгээ, итгэмжлэлийн гүйцэтгэх үүрэг, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замын талаар Засгийн газар, зохицуулагчид, бизнес эрхлэгчид, хэрэглэгчдийн анхаарлыг хандуулж, эцсийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд итгэх итгэлийг бий болгох үүрэг хариуцлагыг нь тодотгох ач холбогдолтой гэж ойлгож байна.

Монгол Улсын Итгэмжлэлийн байгууллага энэ өдрийг хэрхэн тэмдэглэхээр төлөвлөж байна вэ?

Хангамжийн сүлжээний үр өгөөжийг нэмэгдүүлэх гэдэг нь онцлогтой, өргөн хүрээг хамарсан сэдэв. Улс орон болгонд өөрийн гэсэн онцлох бүтээгдэхүүн байдаг. Иймд бид мах, зөгийн бал, ноос, ноолуур зэрэг үндэсний бүтээгдэхүүнийхээ үйлдвэрлэл, худалдааг дэмжих зорилгоор нийлүүлэлтэд нь оролцогч бүх талуудыг хамарсан уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, тухайн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, зах зээлд гаргахад дэмжлэг үзүүлдэг лаборатори, хяналтын ба баталгаажуулалтын байгууллагын үйл ажиллагаа, итгэмжлэлийн үүрэг, ач холбогдлыг таниулахыг зорьж байна. Мөн тохирлын үнэлгээ, итгэмжлэлийн үйл ажиллагааны олон улсын туршлага, өөрсдийн хийж буй ажлын талаар илүү их мэдээллийг нийгэмд хүргэхээр ажиллаж байна.

Хүнсний бүтээгдэхүүний хангамжийн сүлжээнд тулгамдаж буй асуудал юу вэ? Хэрхэн шийдвэрлэх вэ?

Хүнсний аюулгүй байдал нь үндэсний аюулгүй байдлын чухал хэсэг бөгөөд төрөөс баталсан хүнсний салбарын бодлого, авч буй арга хэмжээ түүний хэрэгжилт, хүнсний сүлжээний бүх үе шат дахь хүнсний чиглэлийн үйл ажиллагаа, тэдгээрт тавих хяналт, шалгалт, түүнчлэн хэрэглэгчийн сэтгэл ханамжаар илэрхийлэгдэж байна. Хүнсний аюулгүй байдлыг хангах асуудал нь салбарын төрийн болон төрийн бус байгууллагууд хоорондын ажлын уялдаа, хувийн хэвшлийн идэвхтэй оролцоог шаардсан, бүх нийтийг хамарсан чухал ач холбогдолтой.

Хүнсний бүтээгдэхүүн дэх үлдэгдэл бодисыг хянах, сэргийлэх асуудал олон улсын хүнсний худалдаанд хурцаар тавигдаж байна. Хэрэглэгчдийн хүнсний бүтээгдэхүүнд тавих шаардлага өндөрхийн хэрээр мал амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүнд агуулагдаж байгаа өчүүхэн төдий үлдэгдлийг ч илрүүлэх мэдрэмж өндөртэй, нарийвчлал сайтай лабораторийн аргууд шаардлагатай болж байна.

Гэтэл өнөөдөр хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд сорилт гүйцэтгэдэг итгэмжлэгдсэн лабораториудын хүчин чадал харилцан адилгүй байгаа нь харагддаг. Тухайлбал Евразийн эдийн засгийн комиссын Гаалийн холбооноос баталсан Мах, махан бүтээгдэхүүний аюулгүй байдал гэсэн техникийн зохицуулалтын баримт бичигт заасан нян судлал, хүнд металлын бохирдол, малын эмийн үлдэгдэл, пестицид, инсектицидын үлдэгдэл, цацрагийн үзүүлэлтийг шинжлэх үндэсний лабораториудын чадавхыг 2017 онд судлан тогтоосон байдаг. Судалгаагаар Евразийн эдийн засгийн комиссын Гаалийн холбооноос баталсан “Мах махан бүтээгдэхүүний аюулгүй байдал” техникийн зохицуулалтын баримт бичигт заагдсан арга, аргачлалын дагуу сорилт хийхэд лабораториудад стандартчилсан загвар, урвалж бодис, тоног төхөөрөмж, ажилтны мэргэшил зэрэг шаардлагатай нөөц дутагдалтайгаас тогтоосон үзүүлэлтийн 50 орчим хувийг шинжлэх чадавхтай байлаа.

Хоёрдугаарт, тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээ нь стандарт, техникийн зохицуулалтын шаардлагыг хангаж байгааг баталдаг сорилт, баталгаажуулалт, хяналт зэрэг үйл ажиллагааг багтаасан тохирлын үнэлгээг цогцоор нь хөгжүүлэх шаардлага байна. Өнөөдөр Стандарт, хэмжил зүйн газар болон түүний орон нутгийн салбар хэлтсүүдээс бусад хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын баталгаажуулалтын байгууллага байхгүй. Гэтэл мах, махан бүтээгдэхүүний гарал үүслийг тогтоох, малын эм, бэлдмэл, пестицид, хүнд металлын үлдэгдлийн хяналт, мониторингийн баталгаажуулалт, мал аж ахуй, тариалангийн аж ахуйд хөдөө аж ахуйн зохистой дадал нэвтрүүлснийг баталгаажуулах, органик бүтээгдэхүүний баталгаажуулалт зэрэг төрөлжсөн, мэргэшсэн байгууллагууд үүсч бий болох, ажиллах бололцоотой гэж үздэг.

Та хүнсний лабораторийн талаар хөндлөө. Монгол Улсад ийм төрлийн сорилт гүйцэтгэдэг итгэмжлэгдсэн лабораториуд хэд байдаг, чадавхын хувьд хир байна. Олон улсын жишигт нийцэж байна уу?

2019 оны 1-р улиралд гаргасан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд сорилт гүйцэтгэдэг итгэмжлэгдсэн лабораториудын талаарх тайлан мэдээллээр Монгол Улсад итгэмжлэгдсэн 95 лаборатори ажиллаж байна. Үүнээс:

- Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори, нийслэл болон орон нутгийн сүлжээ лабораториуд, мал эмнэлгийн хүрээлэн-22 (төрийн өмчит);
- МХЕГ-ын дэргэдэх Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори, нийслэл, дүүрэг, орон нутаг, хилийн мэргэжлийн хяналтын сүлжээ лаборатори газар-27 (төрийн өмчит);
- Их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын лаборатори-4 (төрийн 2, хувийн 2);
- Хүнсний үйлдвэрийн дэргэдэх дотоод хяналтын лаборатори-26 (хувийн 25, төрийн 1);
- Хүнсний захын дэргэдэх 4 лаборатори (хувийн өмчит);
- Гаалийн чиглэлийн лаборатори-1 (төрийн өмчит) байна.

Лабораториудын ямар бүтээгдэхүүнд ямар үзүүлэлт, арга аргачлалаар сорилт явуулах чадавхтай болохыг нь итгэмжлэлийн байгууллагаас үнэлж тогтооходоо тухайн лабораторийн хүний нөөц, мэргэшсэн байдал, тоног төхөөрөмж, урвалж, стандартчилсан загвар, арга, аргачлалын хангамж зэрэг техник ур чадвартай нь уялдуулан итгэмжлэлийн хүрээний тодорхойлолтыг ялгавартайгаар олгодог. Иймээс лабораторийн үйлчилгээг хэрэглэгчид өөрсдийн хэрэгцээ, шаардлагыг үндэслэн үйлчлүүлэх

байгууллагаа сонгохдоо итгэмжлэлийн хамрах хүрээг нь анхаарч үзэхийг зөвлөж байна.

Монгол Улсын Итгэмжлэлийн байгууллагаас итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллагуудын үр дүнг хэдэн улс орон хүлээн зөвшөөрч байгаа вэ?

Үндэсний итгэмжлэлийн байгууллага нь Стандартчилал, техникийн зохицуулалт тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай болон бусад хууль, Засгийн газраас батлан гаргасан “Чанарын хөтөлбөр”, “Эрүүл монгол хүн, эрүүл хүнс” гэх мэтчилэн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг ханган, тохирлын үнэлгээний байгууллагын итгэмжлэлийг хэрэгжүүлж байна. Итгэмжлэлийн үр дүнг Олон улсад хүлээн зөвшөөрөх хэлэлцээрт нэгдэх ажиллагаа маань 2012 онд APLAC буюу Ази, номхон далайн лаборатори итгэмжлэлийн хамтын ажиллагааны байгууллагын хэлэлцээрт сорилт, хэмжлийн лабораторийн, 2016 оноос хяналтын байгууллагын итгэмжлэлийн төрлөөр эхэлсэн. Цаашид 2017 онд PAC буюу Номхон далайн итгэмжлэлийн хамтын ажиллагааны байгууллагын хэлэлцээрт бүтээгдэхүүн, менежментийн тогтолцоо (чанар, байгаль орчин, хүнсний аюулгүй байдал)-ны итгэмжлэлийн төрлөөр нэгдээд байна. Үүгээр уламжлан ILAC (Олон улсын лаборатори итгэмжлэлийн хамтын ажиллагааны байгууллага)-ын 100 гаруй, IAF (Олон улсын итгэмжлэлийн форум)-ын 70-аад гишүүн орнуудад үндэсний итгэмжлэгдсэн байгууллагын үр дүнг хүлээн зөвшөөрөх болжээ.

Монгол Улс мал, аж ахуйн орон. Тэгэхээр малын гаралтай түүхий эд бүр тодруулбал махны экспортыг нэмэгдүүлэхэд итгэмжлэлийн байгууллага ямар үүрэг оролцоотой оролцох вэ?

Энэ жилийн Дэлхийн итгэмжлэлийн өдрийн арга хэмжээний хүрээнд үндэсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн, үүний дотор мах, зөгийн балыг экспортлоход бид давуу тал, тулгарч буй бэрхшээлээ тодорхойлж хэлэлцэх, шийдвэр гаргагчид, бизнес эрхлэгчид, хэрэглэгчдийн анхаарлыг ямар асуудалд хандуулж, дэмжлэг, оролцоог нь хангахаа ярилцана. Энэ хүрээнд тодорхой зарим лабораторийг чадавхжуулах, Стандартчилал, техникийн зохицуулалт тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд зааснаар чиглэлийн яамдаас тохирлын үнэлгээний байгууллагыг томилох боломж зэрэг асуудал чухлаар тавигдана. Бид бүтээгдэхүүнээ экспортод гаргана гэж ярьдаг ч угтаа импортлогч орны шаардлагыг судлан, нийцсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, мөн тохирлыг батлах лаборатори, баталгаажуулалт, хяналтын байгууллагаа чадавхжуулах ёстой. Тэгэхээр чанарын дэд бүтцийг бүрдүүлэгч бүх талын үйл ажиллагааг бэхжүүлэх нь бидний хувьд чухал асуудал байсаар байх болно.

ХАНГАМЖИЙН СҮЛЖЭЭНИЙ ҮР ӨГӨӨЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХЭД ИТГЭМЖЛЭЛИЙН ҮҮРЭГ

ЯМАР ХҮНДРЭЛҮҮД БАЙНА ВЭ?

- Олон жилийн турш дэлхийн өнцөг булан бүрт төрөл бүрийн түүхий эд ашиглан бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэж бизнес эрхэлж байсан хэдий ч орчин үед хурд, цар хүрээ, харилцан уялдаатай цогцолбор шинжтэй болсон нийлүүлэлтийн сүлжээ илүү ач холбогдолтой болон өөрчлөгдөж байна.
- Дэлхий нийтийг хамарсан нийлүүлэлтийн сүлжээ нь бизнес эрхлэгчдийг харилцан адилгүй, өөр өөр дүрэм бүхий ялгаатай орчинд үйл ажиллагаа явуулах шаардлагыг бий болгож байна.
- Түүхий эд, бүтээгдэхүүний орц найрлагын чанар, төлөв байдал, гарал үүслийг тодорхойлоход баттай, найдвартай мэдээлэл шаардагдаж байна.
- Инновацийн өсөлт хурдассантай холбоотой бүтээгдэхүүний эрэлттэй байх насжилт богиносож, зах зээлийн нөхцөл таамаглашгүй болж байгаа нь хангамжийн сүлжээн дэх бэрхшээлийг нэмэгдүүлсээр байна.
- Бизнес эрхлэгчдэд өгөгдлийн сангийн аюулгүй байдал, тогтолцооны гажуудлаас үүсэх эрсдэлээ тооцоолдог байхыг шаардаж байна.
- Тогтвортой ханган нийлүүлэгчийг оновчтой сонгох нь зөвхөн байгууллагын санхүүгийн тогтвортой байдлыг хангахаас гадна нийгмийн хариуцлагын гүйцэтгэл, ёс зүйн дадлыг төлөвшүүлэх нөхцөл болж байна.

Бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээ нь даяарчлагдсаар байгаа бөгөөд аж ахуйн нэгжүүд уян хатан байдлаа хадгалахын зэрэгцээ зардлыг оновчтой хянахыг эрмэлзэж байна. Улс орон, бүс нутаг дамжсан нийлүүлэлтийн сүлжээ нь тухайн улс орны хууль, журам, стандартыг баримтлан чанартай, аюулгүй, байгаль орчин болон нийгмийн хариуцлагыг хангасан үйлчилгээ үзүүлэх нь томоохон сорилт болж байна.

Худалдан авалт компанийн зардлын 70 хүртэл хувийг эзлэх болж (эх сурвалж: Худалдан авалт хангамжийн хүрээлэн), аливаа хүндрэл нь тухайн байгууллагын ашигтай ажиллагаа, брэндийн нэр хүнд ба үйлчлүүлэгчийн үнэнч байдалд нөлөөлж болзошгүй юм.

КЕЙС СУДАЛГАА

Нэгдсэн Вант Улсын орон нутгийн удирдлага

Нэгдсэн вант улсын орон нутгийн зөвлөл нь өөрийн нутаг дэвсгэр бүрд асбестын судалгааг итгэмжлэгдсэн байгууллагаар хийлгэхийг шаарддаг. ISO/IEC 17020 стандартын шаардлага хангаж итгэмжлэгдсэнээр судлаачид нь чадвартай, хараат бус, шударга болохоо батлан харуулдаг. Ийнхүү итгэмжлэл нь зөвлөлийг ханган нийлүүлэгчийн сонгон шалгаруулалт явуулахгүй, давтан шалгах шаардлагагүй баталгаатай тайлан хүлээн авах нөхцөлөөр хангаж байна.


ИТГЭМЖЛЭЛ ЯМАР ҮҮРЭГТЭЙ ВЭ?

Итгэмжлэл нь сорилт, шалгалт тохируулга, баталгаажуулалт, хяналт зэрэг тохирлын үнэлгээний үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын техникийн чадавх, нэгдмэл, шударга байдлыг тодорхойлдог.

Олон улсын зөвшилцлийн стандартад тулгуурлан явагддаг итгэмжлэл нь бизнес эрхлэгчдэд төдийгүй нийлүүлэлтийн сүлжээнд тухайн бүтээгдэхүүн нь техникийн шаардлагыг хангасан, хэрэглэхэд аюулгүй гэж итгэлцлийг бий болгосноор бараа бүтээгдэхүүний үнэ цэнийг дээд цэгт нь хүргэж, гэрээнийхээ хүрээнд харилцагч талуудыг сэтгэл хангалуун байх нөхцөлийг бий болгодог.

Худалдааны 80% нь сорилт, шалгалт тохируулга, хяналт, баталгаажуулалт зэрэг тохирлын үнэлгээний үйл ажиллагааг агуулж байдаг (эх сурвалж: OECD). Итгэмжлэл нь хүлээн зөвшөөрөгдсөн баримт бичгийн дагуу тохирлын үнэлгээний байгууллагуудыг хараат бусаар үнэлэх ба ингэснээр тэдгээр байгууллагын шударга, чадавхтай, тууштай байдлыг нь хангуулдаг.

Энэ ч утгаараа итгэмжлэл нь худалдаа, бизнес эрхлэх зардлыг багасгах, технологи дамжуулах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Мөн бизнес эрхлэгч, түншүүдийн хооронд түгээмэл "техникийн хэл" ашиглан бүтээгдэхүүний чанарыг тодорхойлж, улмаар дэлхий нийтийг хамарсан нийлүүлэлтийн сүлжээнд нэгдэх боломжийг бий болгодог (эх сурвалж: Дэлхийн Банк). Дэлхийн Худалдааны Байгууллагын Эдийн Засгийн Судалгаа, Статистикийн хэлтсээс гаргасан тайланд тохирлын үнэлгээний зохисгүй хэрэглээ нь Худалдаанд анхаарах асуудлуудын 10%-ийг эзэлдгийг харуулсан ба итгэмжлэл нь энэ асуудлыг шийдвэрлэх боломжийг олгодог.



КЕЙС СУДАЛГАА

Хангамжийн сүлжээний аюулгүй байдлын менежментийн тогтолцооны баталгаажуулалт (SCSMS)

Итгэмжлэлийн байгууллага нь хангамжийн сүлжээний аюулгүй байдлын менежментийн тогтолцооны баталгаажуулалтыг (ISO 28000) баталгаажуулах байгууллагуудын чадавхыг үнэлдэг.

Тус стандарт нь хангамжийн сүлжээний аюулгүй байдалд учирч болох терроризм, залилан, хулгай зэрэг ноцтой хохирол учруулж болох эрсдэлүүдийг арилгах аюулгүй байдлын менежментийн тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх, тасралтгүй сайжруулахыг шаарддаг.

ХАНГАМЖИЙН СҮЛЖЭЭНД ИТГЭЛЦЛИЙГ БИЙ БОЛГОХ

Өнөөгийн хангамжийн сүлжээний нарийн төвөгтэй байдлыг харгалзан, хэмжилт, сорилт, хяналт, бусад хууль тогтоомж, зах зээлийн секторт хийгдсэн гэрчилгээнд баталгаа гаргах нь нэн чухал байна. Итгэл үнэмшилгүй бол бараа, үйлчилгээний чөлөөт солилцоо нь техникийн саад тотгор эсвэл чанартай холбоотой бэрхшээлийг бий болгох ба ингэснээр импортлогч, хэрэглэгчдийн зардлыг өсгөдөг.

Ийм төвөгтэй байдлын улмаас болж Засгийн газар, зохицуулагчид нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалахад шаардагдах лабораторийн бүх сорилт, хяналт, баталгаажуулалтыг хийхэд зардал хүрэлцээгүй байдаг.

Үүний шийдэл нь Засгийн газрын зүгээс тавигдаж буй шаардлагыг тусгасан зохицуулалтыг бий болгох, нийцтэй байдлыг хангасан гэдгээ харуулахын тулд ажиллах журмыг тогтоох нь хувийн хэвшлийн үйлчилгээ үзүүлэгчид дагаж мөрдөх үйл явцыг баталгаажуулах ажлыг гүйцэтгэх боломжийг олгох явдал юм.

Сорилт, баталгаажуулалт, хяналт зэрэг үйл ажиллагааг багтаасан тохирлын үнэлгээ нь тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээ нь стандарт, техникийн шаардлагыг хангаж байгааг батлахад ашиглагдана.

Зохицуулалт бүхий салбарт тохирлын үнэлгээ нь хууль эрх зүйн шаардлагад нийцэж байгааг харуулдаг бол зохицуулалттай бус салбарт тохирлын үнэлгээ нь тухайн бараа, үйлчилгээ нь хэрэглэгч, импортлогчийн хүсэлтэд нийцсэн эсэхийг тодорхойлж өгдөг байна.

Тохирлын үнэлгээний байгууллага нь ихэвчлэн арилжааны байгууллагууд байдаг бөгөөд тэдгээрийн үр дүн, сорилтын өгөгдөлд итгэх итгэлийг бий болгохын тулд итгэмжлэлийн байгууллагаас тэдгээрийн техникийн чадавхыг нь үнэлж, итгэмжилдэг.



ОЛОН УЛСАД ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨГДСӨН ХАНГАМЖИЙН СҮЛЖЭЭГ ДЭМЖИХ

Лаборатори, хяналтын байгууллага, баталгаажуулалтын байгууллагад чадавхтай байгууллагаас хяналт хийлгэх зорилготойгоор итгэмжлэлийн байгууллагыг бий болгон ажиллуулдаг. Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн итгэмжлэлийн байгууллагууд нь ижил түвшний байгууллагуудаар үнэлэгдэж хоорондоо гэрээ хэлэлцээр хийж байгаа нь бүтээгдэхүүн, үйлчилгээг хил дамнан хүлээн зөвшөөрөхөд тусалж, хангамжийн сүлжээнд итгэх итгэлийг бий болгож дэлхий дахинд худалдаа арилжааны дэд бүтцийг бий болгодог.


Дэлхий даяар улс орнуудын ДНБ-ий 96%-ийг эзэлдэг эдийн засгийн энэхүү зохицуулалтыг баталгаажуулалтын байгууллагуудын магадлан итгэмжлэлийг хариуцдаг IAF, лабораторийн болон хяналтын байгууллагын итгэмжлэлийг ILAC хариуцан ажилладаг байна. Энэхүү тогтолцоо нь дэлхий даяар итгэмжлэлийн байгууллагаас явуулж буй ажлыг баталгаажуулж, нэг итгэмжлэлийн байгууллагаас нөгөөд ижил итгэлцэл бий болгон олон улсын стандартын дагуу ажилладаг. Үүний үр дүнд IAF, ILAC-ын ерөнхий хяналтан доор бүтээгдэхүүн, үйлчилгээг сорьж, шалгаж, баталгаажуулсан байдал нь хаана ч ижил итгэлцэлтэйгээр хүлээн зөвшөөрөгддөг байна. Ингэснээр итгэмжлэл нь олон улсын худалдааны түншүүд хоорондын мэдээллийн нэгдсэн ойлголтыг бий болгож, нэг ижил үнэ цэнэ ойлголтод хүрэх боломжоор хангаж, олон улсын худалдааны нэгдмэл харилцааны хэлбэрийг бий болгодог байна.

Нэгдсэн Вант улсын Эдийн Засгийн болон Бизнесийн Судалгааны Төвөөс хийсэн судалгаагаар жил бүр Их Британийн нэмэлт экспортын 6,1 тэрбум фунт стерлинг нь стандарт, итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээнд үндэслэсэн хэмээжээ. Үүнээс үзэхэд бүтээгдэхүүний аюулгүй, зориулалтандаа нийцсэн байдал нь худалдан авагчдад итгэлийг төрүүлэх тул тэдгээрийг илүү өргөнөөр хүлээн зөвшөөрдөг. Энэхүү тогтолцоо нь худалдаанд учрах техникийн саад тотгорыг арилгаж, олон улсын цогц шинж бүхий нийлүүлэлтийн сүлжээнд итгэх итгэлийг нэмэгдүүлж, ил тод байдлыг сайжруулдаг.

ИТГЭМЖЛЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ: ХАНГАМЖИЙН СҮЛЖЭЭНИЙ ҮР ӨГӨӨЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

Итгэмжлэл нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, барилга байгууламж, эрчим хүч, хувцас, нэхмэл эдлэл, тоглоом, электрон бараа, мэдээллийн технологи, харилцаа холбоо, хүнсний аюулгүй байдал, усан хангамж зэрэг бүхий л нийлүүлэлтийн сүлжээг хамарсан үйл ажиллагаа явуулдаг.

Итгэмжлэл нь баталгаажуулалт, хяналт шалгалт, сорилт, шалгалт тохируулгын үйлчилгээг үнэлэх замаар хангамжийн сүлжээний боломжит эрсдэлийг удирдаж чадахуйц үйлчилгээг санал болгодог. Эдгээр байгууллагын үр чадвар, шударга байдал, чадавхыг харуулах замаар тэдгээрийн эрсдэлийг илүү сайн удирдахын тулд худалдан авалт, хангамжийн сүлжээний менежерүүдийг бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг найдвартай байлгах явдлыг дэмждэг.



КЕЙС СУДАЛГАА

Intermarché-ийн хангамжийн сүлжээний чанар, мөшгих боломж

Францийн супермаркетын сүлжээ, Intermarché нь бүх нийлүүлэгч, бүрэлдэхүүн, үйлдвэрлэлийн бүх сүлжээгээ тодорхойлох, шинжлэх, хянах үүргийг гүйцэтгэдэг бөгөөд үүнд дэлхийн 41 орны 4200 гаруй ханган нийлүүлэгч оролцож, байгаль орчны чанарын гэрчилгээ авсан.

Тэд хангамжийн сүлжээнд хамрагдсан бүх аж ахуйн нэгжүүдийн зураглал, нийлүүлэгчийн гэрчилгээг цуглуулж, шалгаж, ханган нийлүүлэгчийн үйл ажиллагаанд хяналт тавина. Энэ нь үйлдвэрлэгч, борлуулагчийн хувьд үйлдвэрлэлийн гарал үүслийг тодорхойлох, эрсдэлийг бууруулахад тусалдаг байна.

ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

Сүүлийн жилүүдэд Засгийн газар болон зохицуулагчдын хоорондох тохиролцоо гэж итгэмжлэлийг хүлээн зөвшөөрөх хандлага улам нэмэгдэж байна. Жишээлбэл, саяхан Япон, Канад, Швейцарь, Тунис зэрэг улсуудтай гэрээ байгуулсан Европын Холбоо (ЕХ)-ны худалдааны хэлэлцээрт хоорондоо уялдаатай чөлөөт худалдааг баталгаажуулахын тулд итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээг ашиглахыг дурдсан байдаг. Персийн булангийн Хамтын Ажиллагааны Зөвлөл (ГЕН) нь хамтран ажиллах бүхий л талууд бүгд нэгдмэл ойлголттой, харилцан итгэлцлийг бий болгох зорилгоор итгэмжлэл дээр суурилсан зах зээлийн нэгдсэн зохицуулалтыг хэрэгжүүлэхийг санал болгосон байна. АРЕС (Ази Номхон Далайн Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа) нь АПЕК-ийн гэрээнүүдийн тохирлын үнэлгээний бүрэлдэхүүн хэсгийг баталгаажуулах зорилгоор итгэмжлэлийн үйлчилгээг дэмжиж байна.

АСЕАН (Өмнөд Азийн Үндэсний Ассоциаци) нь АСЕАН-ийн салбарын Олон талын хүрээнд хүлээн зөвшөөрөх гэрээ (MRA)-нд цахилгаан болон электрон тоног төхөөрөмж нь тогтоосон шаардлагыг хангаж байгааг нотлоход итгэмжлэлийг шаардахаар оруулсан байна.

Итгэмжлэлийг ийнхүү бүс нутагт болон нэгж улс орнуудын хүрээнд хүлээн зөвшөөрсөн явдал нь Худалдааны гэрээний техникийн саад тотгор, ариун цэврийн болон эрүүл ахуйн арга хэмжээний гэрээний дагуу ДХБ-ын гишүүн орнуудын засгийн газар өөрсдийн үүрэг хариуцлагыг биелүүлэхэд тусалж буй хэрэг юм.


Итгэмжлэлийг мөн бусад асуудлаар ч хүлээн зөвшөөрдөг. Их Британид Төлөөлөн удирдах зөвлөл нь жил бүр сайн засаглалын тайланд итгэмжлэгдсэн ISO 9001-ийн гэрчилгээ олгож, гүйцэтгэлд нь эдийн засгийн түвшинг үнэлдэг Глобал Инновацийн Индексээр шалгуулж байна. Эрсдэлийн менежерүүдийн холбоо AIRMIC-ийн гаргасан саяхны тайлан нь итгэмжлэлийн үнэ цэнэ үнийн эрсдэлийн хэрэгсэл болж байгааг хүлээн зөвшөөрсөн.

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ АЖИЛТНУУДЫГ ДЭМЖИХ

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ХАЙЖ ОЛОХ

Дэлхийн итгэмжлэлийн өдрөөс үйл ажиллагаа нь явагдаж эхлэх “IAF CertSearch” программ нь худалдан авалтын ажилтнуудад дэмжлэг үзүүлэх хэрэгсэл юм. Платформ нь одоогоор итгэмжлэгдсэн нийлүүлэгчдийн 700,000 менежментийн тогтолцооны гэрчилгээг багтаасан байгаа нь худалдан авагчдад тэдний боломжит нийлүүлэгчид ийм гэрчилгээтэй эсэхийг шалгадаг боломжийг олгоно. Энэ нь итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллагаас олгосон гэрчилгээнээс итгэмжлэгдээгүй тохирлын үнэлгээний байгууллагуудын гаргасан гэрчилгээг ялгаж таних, мөн гэрчилгээний жинхэнэ эсэхийг шалгахад тусална.

www.iaf.certsearch.org



КЕЙС СУДАЛГАА

Аюулгүй ажиллагааны схем

Худалдан авах ажиллагааны аюулгүй ажиллагааны схем (SSIP) нь урьдчилсан шалгаруулалтыг багасгах, хангамжийн сүлжээнд эрүүл мэнд, аюулгүй байдлын үнэлгээний зардлыг багасгах, хүнд суртлыг бууруулах зорилготой жижиг бизнесийг дэмжих форум юм.

SSIP-ийн бүртгэлтэй гишүүд нь гуравдагч талын Эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны үнэлгээний бүдүүвчид хандах нээлттэй эрхтэй бөгөөд үүнд гол гүйцэтгэгчид эсвэл худалдааны холбоод зэрэг эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны үнэлгээний бүдүүвчийг багтаасан болно. Бүртгэгдсэн Гишүүн схем нь бүртгэгдсэн бусад гишүүний схем болон Сертификатын Үнэлгээний байгууллагуудтай UKAS SSIP салбарын схемээр дамжуулан хоёр талын харилцан хүлээн зөвшөөрөх харилцаанаас ашиг тус хүртдэг.

2016 оноос хойш форумын гишүүдийн хооронд харилцан хүлээн зөвшөөрөх гэрээ хийгдсэнээс хойш SSIP портоос авсан мэдэгдэл нь үйлдвэрлэл эрхлэгчдийн зүгээс 124 сая фунтын зардлыг бууруулсан байна. SSIP хөтөлбөр нь эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны үнэлгээний процессоор шалгагдсан 71,000 гаруй байгууллагын мэдээллийг хадгалж байдаг ба худалдан авалтын менежерүүдийг энэ бүх мэдээлэлд хандах боломжоор хангадаг байна. Итгэмжлэл нь хууль тогтоомжийг дагаж мөрдөх, гишүүдийн хөтөлбөр хоорондын уялдаа холбоог баталгаажуулдаг.

НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ

Итгэмжлэл нь бизнес эрхлэгчдийн дотоод үйл ажиллагааны эрсдэлийг үнэлэх, хянахаас гадна зах зээл дээр байршдаг бүтээгдэхүүн, үйлчилгээг хянах боломжтой. Ингэснээр итгэмжлэл нь аюулгүй дэлхий ертөнцийг бий болгодог гэдэгт зохицуулагч, худалдан авагч болон ажилтнууд итгэж болно.

[Http://www.publicsectorassurance.org](http://www.publicsectorassurance.org) хаягаар нэвтрэн эрүүл мэнд, аюулгүй байдлын бодлогыг хэрэгжүүлэхэд магадлан итгэмжлэлийн эерэг үр дүнг харуулсан судалгаа шинжилгээ, кейс судалгаа, холбоотой дэмжлэг үзүүлэх нэмэлт мэдээлэл авч болно.

Бизнес нь стандарт, магадлан итгэмжлэлээс хэрхэн яаж хүртэх тухай дэлгэрэнгүй жишээг www.businessbenefits.org-оос авна уу.



БЭЛЧЭЭРИЙН МОНГОЛ МАЛЫН МАХНЫ ЭКСПОРТЫГ НЭМЭГДҮҮЛЭХЭД ТАВИГДАХ ГОЛ ШААРДЛАГА

Хүн төрөлхтний бүхий л хүнсний дотроос шим тэжээл хамгийн ихээр цогцолсон нь махан хоол гэж үздэг. Судлаачдын тогтоосноор Монгол хонины маханд төгс уургийн амин хүчил-триптофан, холбогч эдийн аминхүчил-оксипролиний харьцаа дунджаар 7.5 байдаг. Дээрх харьцаа нь таваас доошгүй байвал тухайн махыг сайн чанартайд тооцож байхыг Дэлхийн хүнс, хөдөө аж ахуйн байгууллага санал болгосон байдаг ажээ.

Аминдэмийн судалгаагаар Монгол малын маханд B1, B2, PP аминдэм бусад орны малын махнаас 10%-иас 2 дахин илүү байдаг. Бэлчээрийн малын махан дахь үлэмж язгуур махбод буюу макро элементийн агууламж бусад орны малын махтай адил түвшинд, харин бичил язгуур махбод буюу микроэлементийн агууламж давамгайлах хандлагатай байдгийг судлаачид нэгэнтээ тогтоосон юм.

Нэн ялангуяа цус төлжүүлэх процесст онцгой чухал үүрэгтэй төмөр болон ферментүүдийн найрлагад оролцдог зэс зэрэг нь 1.8-3 дахин их хэмжээтэй байдаг нь тогтоогджээ. Монгол малын махыг улсынхаа гол брэнд бүтээгдэхүүн болгох боломжийн төлөө маркетинг менежментийн шинэ алхам хийн, мал эмнэлгээ дэмжиж ажиллах нь засаг захиргаа, удирдлагын бүх шат дамжлага, аж ахуйн нэгж, ард иргэдийн хувьд үндсэн хуулинд нийцүүлсэн чухал үүрэг гэж үзэх нь чухал байна.

Дэлхийн өнцөг булан бүрт худалдаалагдаж байгаа Австрали, Шинэ Зеланд зэрэг орныхоос Монгол малын махны чанар илүү юү гэхээс дутуугүй гэж хүн бүхэн ярьдаг ч үүнийгээ батлан харуулахын

тулд олон улсын байгууллагуудаас тавьж байгаа шаардлагад нийцсэн бодитой шийдвэрүүдийг нэн тэргүүнд гаргаж ажил болгохыг эрэлт хэрэгцээ, цаг хугацаа, зах зээл шаардсаар ирлээ.

Мах экспортлохын тулд дор дурдсан хамгийн наад захын шаардлага хангасан байх учиртай. Үүнд:

1. Олон улсад болоод үндэсний хэмжээнд итгэмжлэгдэн хүлээн зөвшөөрөгдсөн лаборатори, техникийн болон боловсон хүчний чадавх;
2. Мал, амьтны бүртгэл мэдээллийн тогтолцоо;
3. Малын эрүүл мэндийн статус, тухайлбал гоц халдварт болон зооноз өвчнөөс эрүүл болохыг ДМАЭБ-аар баталгаажуулсан байх, ядахдаа тухайн улс засаг захиргааны нэгж, бүс, аймаг, сум, багийн түвшинд нотлон харуулах тогтолцоо, баримт бичгийн бүрдүүлэлт;
4. Малын эмийн зүй зохистой хэрэглээ, мал амьтны гаралтай бүтээгдэхүүнд эмийн үлдэгдэлгүй гэдгээ нотлох;
5. Мал нядалгааны үйлдвэрүүдийн итгэмжлэл, ариун цэвэр эрүүл ахуйн байдал.

Экспортлох мах, махан бүтээгдэхүүнд тавигдах шаардлага. Үүнд:

1. Малын гарал үүсэл эх сурвалж тодорхой;
2. Мал бэлтгэл болон нядалгааны үеийн шаардлага;
3. Импортлогч орны шаардлагад нийцүүлэх;

Шинжилгээний гол үзүүлэлтийг хангасан байх. Үүнд:

1. Мал эмнэлэг ариун цэврийн үзлэг шинжилгээ (чанар, нян, мөөгөнцөр судлал г.м)
2. Гоц халдварт болон зооноз өвчний шинжилгээ (шүлхий, бог малын мялзан г.м)
3. Үлдэгдлийн шинжилгээ (малын эм, пестицид, даавар гэх мэт)
4. Хортой элемент, цацрагийн шинжилгээ зэрэг болно.

Махны экспортын үйл ажиллагаанд эрүүл, аюулгүй байдлын баталгааг хангавал гэж дахин дахин тодруулж хэлдэг.

Энэ нь дээр дурдсан шинжилгээний гол үзүүлэлтийг харилцан тохиролцох, олон улсын худалдаанд хориглосон гоц халдварт, зооноз өвчнөөр тайван, мөн эм, даавар, пестицидын үлдэгдэл, хүнд металл, цацраг изотоп байгаа эсэхийг нотолсон тандалт судалгааны үр дүн, хөтөлбөртэй байх явдал юм.

Тэгвэл Монгол малын мах эрүүл, цэвэр, гэж бид хий дэмий цээжээ дэлдэх бус үнэхээр цэвэр гэдгээ шинжлэх ухааны үндэслэлтэйгээр дээр дурдсаны дагуу батлан харуулах хэрэгтэй байна. Монгол малын мах амт, чанар сайтай гэдэг ч экспортолж чадахгүй байгаагийн шалтгаан нь эрүүл, аюулгүй гэдгээ бүрэн дүүрэн батлан харуулж чадахгүй байгаатай холбоотой юм.

Эрүүл, аюулгүй байдлын баталгаа гэж юуг хэлээд байна вэ?

Юуны өмнө экспортлогч, импортлогч орны хооронд Засгийн газрын хэлэлцээр хийгдсэний дараа мал эмнэлгийн салбарын гэрээ хэлэлцээр хийгддэг. Өөрөөр хэлбэл мах авах сонирхолтой байгаа орны зүгээс эрүүл, аюулгүй байдлын баталгааг гаргаж өгөхийг шаарддаг. Бид мах импортолж байгаа орны зүгээс тавьж байгаа мал эмнэлгийн шаардлагад нийцүүлсэн үйл ажиллагаа явуулж байж л мах экспортлох эрхтэй болдог.

Олон улсын хэмжээнд хүнсний зориулалтын мал, амьтдыг тусгайлан авч үзэж эрүүл мэндийн байдлаас гадна, тэдгээрийн гаралтай

бүтээгдэхүүнд малын эм, пестицид, даавар, хүнд металлын үлдэгдэл, бохирдол, малын тэжээлийн хяналтуудад онцгой анхаарах болсон. Түүнчлэн малын гаралтай бүтээгдэхүүнд жил бүр тодорхой төлөвлөгөөтэйгөөр эмийн үлдэгдлийн хяналт, тандалтыг хийж баталгаажуулахыг шаарддаг болсон ба үлдэгдэл илэрсэн бүтээгдэхүүнийг борлуулах, экспортлохыг ч хориглодог. Өөрөөр хэлбэл импортлогч орнуудын зүгээс малын мах, махан бүтээгдэхүүнд эмийн болон бусад химийн бодисын үлдэгдэлгүй, хүний бие махбодод хор учруулахааргүй үлэмж бага хэмжээнд байгааг нотлохыг шаарддаг. Тухайлбал ОХУ-ын эрх бүхий байгууллагаас ирүүлсэн мал эмнэлэг, ариун цэврийн шаардлагадаа тухайн бүтээгдэхүүнийг экспортлохынхоо өмнө тэдгээрт хорт элемент (хар тугалга, хүнцэл, кадми, мөнгөн ус), пестицид, диоксан, цацрагийн бохирдол (цезий 137, стронций 90), малын эмийн (хлорамфеникол, тетрациклиний бүлгийн антибиотууд, гризин, бацитрацин, нитрофуроний бүлгийн антибиотууд) үлдэгдэлгүй болохыг нотолсон лабораторийн баталгаа, түүнчлэн хүнсэнд хэрэглэж байгаа мал амьтны гарал үүсэл, эх сурвалжийн талаарх найдвартай мэдээлэл зэргийг шаардаж байна.

Үлдэгдэл бодисыг хянах, сэргийлэхэд чиглэсэн эрх зүйн зохистой орчныг бүрдүүлэх, экспортлогч орнуудад зөвлөх замаар худалдааг хөнгөвчлөх, өргөжүүлэх ажлыг олон улсын холбогдох байгууллагуудаас хэрэгжүүлсээр байна. Иймээс манай улс нэн тэргүүнд олон улсын худалдаанд тавьж буй шаардлагад нийцүүлэн эрх зүйн орчноо бүрдүүлэн Монгол малын махны цэвэр, аюулгүй гэдэг баталгааг гаргаж тавих шаардлагатай болж байна.

Ц.Энхтуяа,
УМЭАЦТөв Лабораторийн Хүнсний Эрүүл Ахуй
Үлдэгдлийн тасгийн дарга, зөвлөх эмч

С.Цэрэнчимэд,
УМЭАЦТөв Лабораторийн Ерөнхий эмч,
Мал эмнэлгийн ухааны доктор (Ph.D), зөвлөх эмч





МАЛЫН ЭМ БЭЛДМЭЛ, ДААВРЫН ХЭРЭГЛЭЭ, ТҮҮНИЙ ЭЭРЭГ БА СӨРӨГ ҮР ДАГАВАР

Орчин үед эрчимжсэн аж ахуйд өндөр үйлчилгээтэй эм, биобэлдмэл түлхүү ашиглах замаар мал, амьтнаас авах ашиг шимийг асар хурдацтай нэмэгдүүлэх болжээ. Уламжлалт бэлчээрийн мал аж ахуй нь мал амьтдад өргөн уудам бэлчээрт олон төрөл зүйлийн өвс ургамал, цэнгэг ус, байгалийн эрдэст долооц олж идэх боломж олгодог бол эрчимжсэн аж ахуй нь эсрэгээрээ хязгаарлагдмал байр, бэлчээрт үй олноор нь хашиж өсгөх, тусгайлсан үйлчилгээтэй эм, бэлдмэлийн орцтой цөөн тооны үр тарианы хольц бүхий үржилт, өсөлт, ашиг шимийн гарц дэмжсэн тэжээл зориудаар олгодгоороо эрс ялгаатай юм. Ийм учраас эрчимжсэн мал аж ахуйгаас богино хугацаанд арвин ашиг шим авах боломж бүрддэг давуу талтай ч нөгөө талаар түүний ашиг шимээр дамжин элдэв төрлийн эм, вакцин, дааврын үлдэгдэл хүнсний хэлхээнд дамжих, улмаар нийтийн эрүүл мэндэд эрсдэл учруулах аюултай байдаг. Түүнээс гадна эрчимжсэн аж ахуйн мал, амьтан төрөл бүрийн халдварт өвчинд илүү мэдрэмтгий, дархлаа, тэсвэрт чанар багатай байдгаас өвчин эмгэгээс сэргийлэх, эмчлэх эмийн бодисын хэрэглээ дагаад өсдөг байна.

Мал аж ахуйд эм, бэлдмэлийг олон зорилгоор хэрэглэдэг. Тухайлбал тодорхой өвчнөөс сэргийлэх, эмчлэх, малд зарцуулах тэжээлийн жин, хэмжээг бууруулах, шингэцийг сайжруулах, үржилт, өсөлтийг дэмжих, түүнчлэн мал, амьтдын стрессийг бууруулах, тайвшруулах гэх мэт. Эмийг зөвхөн эмчилгээний зорилгоор ашигладаггүй бөгөөд хэрэглэх зорилго, аргыг үл харгалзан фармакологийн идэвхт бүхий л бодисыг "Малын эм" гэж нэрлэж хэвшсэн. Тиймээс малын тэжээлийн зарцуулалт, шингэцийг сайжруулах болон үржилт,

өсөлт дэмжих бодисыг малын эм гэсэн ойлголтод хамруулж үздэг байна.

"Өвчин хянах, урьдчилан сэргийлэх төвийн (Center for Disease Control and Prevention) мэдээлснээс эрчимжсэн аж ахуйн мал, амьтны тэжээлийн нэмэлтийн антибиотикийн хэрэглээгээр АНУ, БНХАУ тэргүүлдэг бөгөөд үхэр, хониныхыг бодвол гахай, тахианы аж ахуйд антибиотикийн хэрэглээ 5-10 дахин өндөр байдаг байна.

Малд эм бэлдмэл, даавар хэрэглэхийн ач холбогдол, эрсдэл:

Мал амьтад нь хүнтэй нэгэн адил өвчилж, осолд өртдөг бөгөөд тэднийг элдэв өвчнөөс хамгаалах хэрэгтэй. Ийм болохоор өвчин эмгэгээс сэргийлэх, өвчилсөн тохиолдолд эмчлэхэд зориулж олон төрлийн эм бэлдмэл зохион бүтээж, ашигласаар ирсэн. Тухайлбал тэжээлийн үр ашгийг дээшлүүлэх, өсөлтийг дэмжихийн тулд эм бэлдмэлийг эмчилгээнийхээс бага тунгаар хэрэглэн мах, өндөг, сүүний гарцыг нэмэгдүүлэх, тэжээл бага зарцуулах боломжтой болдог. Тодруулбал эрчимжсэн мал аж ахуй эрхэлдэг орнууд гунжин үнээнд даавар хэрэглэснээр өсөлтийн эрчим идэвхжүүлж, тэжээлийн үр ашгийг сайжруулдаг. Ингэснээр бэлдмэл хэрэглэсэн мал амьтдын идсэн тэжээл илүү хэмжээний мах болон хувирах бөгөөд бэлдмэл хэрэглээгүй малыг бодвол бага хэмжээний тэжээл зарцуулдаг. Ингэснээр мал амьтны нядалгааны жинд хүрэх хугацаа багасаж, фермерүүдэд зардал хэмнэх боломж олгоно гэсэн үг.

Өсөлтийн зарим дааврын бэлдмэл хэрэглэснээр тэжээлийг өөхгүй мах болгож хувиргах боломж ч бүрдүүлнэ. Хэрэглэгчид өөхгүй махыг илүүд

үздэгтэй уялдан тухайн мал, махны борлуулалт, үнэ цэнэ нь нэмэгддэг болохоор дааврын бэлдмэлийн өөх багасгах үйлчилгээ фермерүүдэд таатай боломж бүрдүүлдэг. Түүнчлэн эм, дааврын бэлдмэл саалийн үнээний сүүний гарц, үр ашгийг нэмэгдүүлэхэд ч мөн нэгэн адил нөлөө үзүүлдэг.

Дааврын бэлдмэлүүдийг дотор нь анабол дааврын төрлийн өсөлт идэвхжүүлэгч, натурал гаралтай бэлгийн стероид, нийлэг стероид нэгдэл, нийлэгжүүлсэн стероид бус бодис, полипептид даавар гэх мэт олон дааврууд байдаг.

Дааврын эм болон дааврын үйлчилгээтэй эмийг мал аж ахуйд хэрэглэснээр олон чухал дэвшил гарсан ч бас сөрөг үр дагавар дагуулсаар байна. Тухайлбал стероид дааврууд малын гаралтай бүтээгдэхүүнээр хүний биед орлоо гэхэд ходоод гэдэсний замд хувирч өөрчлөгдөхгүйгээр шимэгдэн үйлчилгээгээ хадгалах аюултай байдгаараа тэдгээрийн үлдэгдлийн тухай асуудал онцгой анхаарал татдаг.


АНУ-д анабол дааврын төрлийн өсөлт идэвхжүүлэгч эм хэрэглэхийг зөвшөөрдөг бол эдгээр эм хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй учраас Европын Холбоонд (ЕХ) эдгээр эмүүд ердийнх эсвэл нийлэг эсэхээс үл хамааран махны чиглэлийн малд хэрэглэхийг нь 1988 оноос хориглосон юм.

Мал эмнэлгийн одоогийн практикт өвчнөөс сэргийлэх, бууруулах, тэжээлийн үр ашгийг сайжруулах зорилгоор малын тэжээлд бага хэмжээний антибиотик нэмдэг бөгөөд энэ нь өвчнөөс эмчлэн сэргийлээд зогсохгүй тэжээлийн үр ашгийг дээшлүүлэхэд ихээхэн ач холбогдолтой болохыг олон судлаачид туршилтаар баталсан байна. Хэдийгээр мал, амьтны эрүүл мэнд, ашиг шимийн гарц, чанарын хувьд дээр дурдсан ашигтай тал олон байвч энэ нь хүнсээр дамжин хүний эрүүл мэндэд хэрхэн нөлөөлөх, эрсдэл буй эсхийг мөн адил онцгойлон анхаарч авч үзэх ёстой болдог.

Хүнсний зориулалтын мал амьтдад эм бэлдмэл, даавар хэрэглэхэд үлдэгдэл нь хүнсэнд хэрэглэх мах, сүү, өндгөнд илэрч болно. Эм, дааврыг мал, амьтдад малын эмчийн зааврын дагуу хэрэглэж, бие махбодоос эм, дааврын бодис бүрэн гадагшилж дуусах хангалттай хугацааг хатуу баримтлах нь мал амьтны гаралтай бүтээгдэхүүнд даавар, эмийн үлдэгдэл байхгүй байх, ингэснээр эрсдэлд орхоос сэргийлэх боломжтой.

Малын эм бэлдмэл, дааврын худалдаа, хэрэглээ замбараагүй болсон, малын эмчээсээ асуулгүй дур мэдэн эм, дааврыг хэрэглэдэг, цээрлэх хугацааг баримталж чаддаггүй, хэрэглэсэн эм нь баталгаагүй байдаг зэргээс болж үлдэгдлийн асуудал хурцаар хөндөгддөг.

Мал аж ахуйд эм бэлдмэл, даавар их хэмжээгээр, замбараагүй хэрэглэснээс тэдгээрийн эх бодисын үлдэгдэл, түүний метаболитууд мал амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүнд үлдэх магадлалыг улам нэмэгдүүлдэг. Иймээс хүнс үйлдвэрлэлийн зохих үе шатанд эм бэлдмэл, дааврын үлдэгдэл болон түүнийг үүсгэдэг эмийн бодисын түвшнөөр нийгмийн эрүүл мэндэд үзүүлэх хор холбогдлыг тодорхойлдог. Эм бэлдмэл, дааврын үлдэгдлийн эрсдэлд хүргэхүйц түвшнээс болж мал, амьтан хордох, гэдэс ходоодны ашигтай нянгийн төрөл зүйл, тоо хэмжээ өөрчлөгдөх, бие махбодын дархлаа, ферментийн хэвийн бус



Антибиотикт тэсвэртэй хамгийн аюултай нянгууд

байдал бий болгох улмаар удам зүйн гажиг, хорт хавдар үүсгэх эрсдэл дагуулдаг. Сүүлийн жилүүдэд антибиотикт тэсвэртэй нянгийн тухай мэдээлэл (1-р зураг) улам бүр нэмэгдэж байгаагаас үзэхэд зонхилгогч антибиотикт тэсвэртэй үүсгэгчийн (*Neisseria gonorrhoeae*, *Acinetobacter baumannii*, *Staphylococcus aureus*, *Burkholderia cepacia*, *Pseudomonas aeruginosa*, *Clostridium difficile*, *Escherichia coli*, *Mycobacterium tuberculosis*, *Klebsiella pneumoniae*, *Streptococcus pyogenes*) халдвар анхаарал татахуйцаар ихэсч байна. Зөвхөн Америкийн нэгдсэн улсад нийт антибиотикынхаа 80 хувийг мал аж ахуйн салбарт хэрэглэдэг ч жилдээ 2 сая хүн нянгийн халдвараар өвчилж 23000 хүн амь эрсэдсэн байна.

Эм бэлдмэл, дааврын үлдэгдэл, тэдгээрийн хор судлалын ач холбогдол:

Хүнсний хангамжийн хүрээнд чухам ямар үлдэгдэл, бохирдол байгааг мэдэх гэсэн олон нийтийн хүчтэй дуу хоолой, түүнчлэн хүнсний бүтээгдэхүүн нийгмийн эрүүл мэндэд нөлөөлж болох үлдэгдлээс ангид байх ёстой гэсэн шахалт шаардлага сүүлийн жилүүдэд улам бүр нэмэгдсээр байна. Энэ асуудалд маш болгоомжтой хандах хэрэгтэй. Орчин үед огт үлдэгдэлгүй хүнс үйлдвэрлэх боломжгүй нь тодорхой. Онолын хувьд энэ нь малын эм бэлдмэл хэрэглэхийг бүхэлд нь хориглоход хүргэх тул орчин үеийн мал

аж ахуйн нөхцөлд үүнийг хүлээн зөвшөөрөхөд нэн бэрхшээлтэй юм. Нөгөө талаар хүнсэнд эм бэлдмэл, дааврын үлдэгдэл ямар нэг хэмжээнд аль нэг хэлбэрээр байхдаа заавал хортой байх (1-р хүснэгт) албагүй. Иймээс малын эмийг хэрэглэж болно, болохгүй гэхээсээ илүү түүнийг зүй зохистой хэрэглэх, малын эмийн үлдэгдлийн хор холбогдлын талаар зөв мэдээлэлтэй, ямар эмийг хэрэглэж болох болохгүй талаар зөв ойлголттой байх нь хамгаас чухал юм.

Бэлчээрийн мал аж ахуйтай, химийн бодисын хэрэглээ харьцангуй бага манай орны мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн экологийн цэвэр гэж хэлэх бүрэн үндэслэлтэй нь олон улсын зах зээлд хүчтэй өрсөлдөгчийн байр суурь эзлэх давуу тал юм. Үүний тулд бид малын эмийн импорт, хэрэглээг эмх цэгцэнд оруулах, бүртгэлийн нарийн тогтолцоотой болгох, антибиоик хэрэглэсэн бол түүний биеэс гадагшлах хугацааг хатуу баримтлах, антибиотик хэрэглээгүй гэдгийг нотлох тандалт судалгаа явуулах, үндэсний үлдэгдлийн хөтөлбөрийг нэн яаралттай баталгаажуулж түүний хүрээнд эрчимтэй үйл ажиллагаа зохион байгуулах, үлдэгдлээс ангид гэдгээ дэлхий нийтийн зах зээлд нотлох зайлшгүй шаардлага тулгарч байна.



УМЭАЦТЛ-д хийгдсэн зарим судалгаагаар малын эмийн үлдэгдэл мах, сүү, өндгөнд илрэх тохиолдол харьцангуй цөөн боловч, үлдэгдэл илэрсэн тухайн аж ахуйн мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг хяналтад авах, хэрэглээг зохистой болгох, холбогдох мэдээллээр хангах, эрсдэлээс сэргийлэн сурталчлах явдал дутмаг байна.

2006, 2008, 2011 онд хийсэн УМЭАЦТЛ-ийн судалгаагаар Монгол малын мах, махан бүтээгдэхүүнд пенициллин, стрептомицин, эритромицин, ципрофлаксацин, тетрациклиний үлдэгдэл илрээгүй. Харин 2011 онд бидний шинжилсэн дээжийн 13,3 хувьд нь 0.3-3.7 мкг/кг хэмжээгээр хлорамфеникол илэрч байв.

2012–2013 онд төвийн бүсийн аймгуудыг хамруулан хийсэн “Мах, сүүн дэх үлдэгдлийн судалгаа, эрсдэлийн үнэлгээ” судалгаагаар судалгаанд хамрагдсан нийт малын маханд сульфонамидын бүлгийн эм илрээгүй боловч 10,45%-д хлорамфениколын үлдэгдэл дунджаар $0,05 \pm 0,01$ мкг/кг, 12,7%-д тетрациклиний бүлгийн эмийн үлдэгдэл зөвшөөрөгдөх хэмжээнээс (MNS CAC MRL:2 2009 стандартад тетрациклиний бүлгийн эмийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ 200 мкг/кг байхаар заасан байдаг) бага буюу дунджаар $5 \pm 1,5$ мкг/кг илэрсэн ба эрүүл мэндэд үзүүлэх эрсдэлийн хор аюулын коэффициент 2,06-4,34 буюу маш бага эрсдэлтэй байгааг тогтоосон. Авермектиний бүлгийн эмийн үлдэгдэл зөвшөөрөгдөх хэмжээнд (MNS CAC MRL:2-2009 стандартад авермектиний бүлгийн эмийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг 15 мкг/кг байхаар заасан байдаг) хэдий ч нийт дээжний 39%-д дунджаар $11,8 \pm 1,3$ мкг/кг илэрч байсан ба хор аюулын коэффициент 10,62-16,99 буюу хүний эрүүл мэндэд эрсдэл учруулах түвшинд хүрч болзошгүй байна гэж үзсэн. Дашрамд дурдахад 2017 онд MNS CAC MRL:2-2009 стандарт–д нэмэлт өөрчлөлт оруулан MNS CAC MRL:2017 стандартыг батлуулсан.

2015 онд хүнсний зах дээр худалдаалагдаж байсан хонины мах гадны үнэр, амттай байна гэсэн гомдол гаргасны дагуу хүнсний захын лабораториос илгээсэн дээжид эмийн үлдэгдлийн шинжилгээ хийхэд антибиотик (хлорамфеникол, тетрациклиний болон сульфонамидын бүлгийн эм, пенициллин), гормон (кленбутерол) илрээгүй, харин ивермектиний үлдэгдэл 101–110 мкг/кг хэмжээтэй илэрч, зөвшөөрөгдөх хэмжээ (15 мкг/кг)-нээс хэтэрсэн дүн гарч байв. Энэ нь малд эм хэрэглэсний дараа биеэс гадагшлах хугацаа дуусаагүй байхад нядалж хүнсэнд хэрэглэсэнтэй холбоотой юм.

2006–2008 онд хийсэн “Малын гаралтай бүтээгдэхүүнд антибиотикийн үлдэгдлийн шалтгааныг тогтоосон дүн”, 2011 онд хийсэн “Баруун бүс нутгийн малын махан дахь үлдэгдэл бодисын тандалт шинжилгээ” судалгаагаар мал эмнэлгийн салбарт хэрэглэдэг эмийн үлдэгдэл илрээгүй ба энэ үр дүн нь тухайн үедээ монгол малын мах, махан бүтээгдэхүүн экологийн цэвэр байгаагийн нэг суурь үндсэн үзүүлэлт болж байв. Харин 2012-2013 оны судалгаа, 2015 онд хүнсний зах дээр худалдаалагдаж байсан маханд ивермектиний үлдэгдэл илэрч байгаа нь эмийн замбараагүй, хяналтгүй хэрэглээ, эмийн шошгон дээрх гадагшлах хугацааг баримтлаагүй зэрэгтэй холбоотой гэж үзэхээр байв.



Малын эм бэлдмэл, даавар хүнсний мал, амьтанд хэрэглэх тохиолдолд тухайн малын гаралтай бүтээгдэхүүний аюулгүй байдлын талаар онцгойлон анхаарах хэрэгтэй байдаг ба улс орон бүр өөр өөрийн зохицуулалттай байдаг.

Манай улсын хувьд энэхүү зохицуулалт хараахан бүрдээгүй байгаа ч бэлтгэл ажлууд ялангуяа лабораторийн шинжилгээний арга, аргачлал, техникийн болон боловсон хүчний чадавх олон улсын жишигт дүйцэхүйц түвшинд хүрч чадсан нь нэн сайшаалтай. Цаашид үүнийг улам бүр чадавхижуулан бэхжүүлэх талд төрийн бодлогоор дэмжих зайлшгүй шаардлага ч тулгарч байна.

Малын гаралтай хүнсний бүтээгдэхүүн дэх эмийн үлдэгдлийг бууруулахын тулд энгийн боловч хамгийн чухал зүйлийн нэг нь эмийн хэрэглээний оновчтой системийг бий болгох, малчид дур мэдэн эм тариа хэрэглэдэггүй байх, малд өгсөн эм, холбогдох үлдэгдэл малын биеэс бүрэн гадагшилсан үед малын гаралтай хүнсний бүтээгдэхүүнийг хэрэгцээлдэг байх явдал юм. Тиймээс малчид болон мал бүхий иргэдэд эмийн үлдэгдлийн хор холбогдлыг сайтар ойлгуулах талаар мэдээлэл сурталчилгааг эрчимжүүлэх нь чухал юм. Иймээс малын эм, даавар, пестицид, аюултай байж болох химийн бусад хортой бодисын үлдэгдэл (үл хүлцэх хэмжээ) эсэхийг тандан тогтоох, эдгээрээс ангид,

хязгаарлагдмал гэдгээ нотлох үлдэгдлийн үндэсний хөтөлбөр батлан хэрэгжүүлэх ажил хүлээгдсээр ирлээ. Үлдэгдлийн үндэсний хөтөлбөрийн гол зорилго нь улсын хэмжээнд мал амьтны гаралтай бүтээгдэхүүн дэх үлдэгдлээс үүсч болох аюулыг үнэлэх, мэдээлэх, биед нь үлдэгдэл аюултай хэмжээнд буй мал амьтдыг нядруулахгүй байх, аюултай хэмжээний үлдэгдэл агуулсан мал амьтдыг нядалсан бол хүнсний сүлжээнд тэдгээрийн аюултай байж болох эд эрхтнийг оруулахгүй байхыг хянах явдал юм. “Үлдэгдлийн Үндэсний Хөтөлбөр”-ийг хэрэгжүүлснээр малын маханд эмийн үлдэгдэл байгаа эсэхийг нотлох, илэрсэн тохиолдолд түүнийг бууруулах, арилгах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, аймаг, нийслэл, дүүрэг, хүнсний захын мал эмнэлгийн лабораторид үлдэгдлийн урьдчилсан шинжилгээг түргэн тестийн аргаар хийх чадавх бий болгох нөхцөл бүрдэнэ.

Үлдэгдлийн хяналтын тогтолцоог бий болгох явдал нь сонголтын асуудал биш бөгөөд энэ нь зайлшгүй хийх, бий болгох ёстой зүйл бөгөөд олон улсын худалдаанд тавигдаж буй чухал шаардлага юм. Монгол Улсын Их хурал, Засгийн газраас нийтийн эрүүл мэндийг хамгаалах, экспортыг нэмэгдүүлэх зорилгоор олон улсын жишиг шаардлага, стандартыг баримтлан үлдэгдлийн хяналтын тогтолцоог улам боловсронгуй болгох, хэрэглэгчдийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэхэд үндэсний үлдэгдлийн хөтөлбөр батлан хэрэгжүүлэх нь онцгой чухал ач холбогдолтой байна.

*Ц.Энхтуяа,
УМЭАЦТөв Лабораторийн Хүнсний Эрүүл Ахуй
Үлдэгдлийн тасгийн дарга, зөвлөх эмч*

*С.Цэрэнчимэд,
УМЭАЦТөв Лабораторийн Ерөнхий эмч,
Мал эмнэлгийн ухааны доктор (Ph.D), зөвлөх эмч*





МОНГОЛ УЛС ДАХЬ УРГАМАЛ ХАМГААЛЛЫН БОДИСЫН ХЭРЭГЛЭЭ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Монгол Улсын хүн амын хүнсний хэрэгцээний 70%-ийг ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүн эзэлдэг. Манай орны стратегийн гол бүтээгдэхүүн болох буудай нь гурилын үйлдвэрийн үндсэн түүхий эд бөгөөд ургалтын болон хадгалалтын үедээ өвчин, хортон шавж, мэрэгч зэрэг хөнөөлт организмд нэрвэгдэх, хадгалалтын горим мөрдөөгүйгээс чанараа ихээхэн хэмжээгээр алдах зэргээр эдийн засгийн хохирол учруулахаас гадна хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэг.

Монгол Улс газар тариалан, ургамал хамгаалалд химийн арга хэрэглээд нэгэн жарны нүүр үзэж байгаа боловч тэдгээр химийн бодисын хэрэглээнд хяналт тавих, хөдөө аж ахуйн зөв дадал эзэмшүүлэх, тандалтын тогтолцоо, пестицидийн зөв менежментийг бүрдүүлэх асуудал дээр тодорхой үр дүнд хүрч чадаагүй л байна.

Пестицидийг импортоор орж ирэх явцад хяналт тавьдаг ч тариалан эрхлэх явцад хяналт тавьдаггүй, иргэд химийн бодистой харьцах үедээ хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм, хэрэглэх зааврыг мөрдөн ажилладаггүй, сургалтад бүрэн хамрагддаггүй, өөрөөр хэлбэл, хөдөө аж ахуйн зөв дадал одоо хүртэл нэвтрээгүй, пестицидийн мэдээллийн нэгдсэн сан байхгүй, төмс, хүнсний ногоон дахь пестицидийн үлдэгдэл хэмжээг зөв тодорхойлон үнэлгээ, дүгнэлт өгч чадахгүй байгаа дутагдал байсаар байна.

Ургамлын өвчин, хог ургамал, хортон шавж, өт авгалдай, мэрэгч, амьтдын эндо, экзопаразиттай тэмцэхэд хэрэглэдэг хөдөө аж ахуй, газар тариалан, ахуйн зориулалтын химийн бодисыг олон улсын нэршлээр пестицид гэнэ.

Пестицидийг гол төлөв хөдөө аж ахуйд хэрэглэдэг боловч өнөөгийн байдлаар бүртгэгдээд байгаа 200 орчим пестицидийн тал хувийг эмнэлэг, ресторан, хоолны газрууд, хортон шавж устгах компани зэрэг хөдөө аж ахуйн бус байгууллагуудад өргөн хэрэглэж байна.

Эрдэмтдийн үзэж байгаагаар пестицидийг хэзээ, хэн, ямар нөхцөлд яаж хэрэглэх талаарх заавар, журмыг сайтар мөрдөж ажилласан тохиолдолд хэрэглэгчдэд очих хүнсэнд агуулагдах пестицидийн

үлдэгдэл хэмжээ үлэмж бага байдаг байна. Харин пестицидийг зөв хэрэглэх талаар зохих заавар, журмыг мөрдөж ажиллаагүй тохиолдолд бие махбодод хуримтлагдаж хордуулах, харшил, хавдар үүсгэх зэргээр хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэг болохыг судалгаагаар нотолжээ.

Пестицид нь хүн болон амьтны бамбай булчирхай, бусад даавруудад өөрчлөлт оруулж, дархлалын системийг гэмтээн, хавдар, өмөн үү үүсгэх, хүний оюуны чадварыг сааруулах эрсдэлтэй төдийгүй эмэгтэйчүүдийн эмгэг, дутуу төрөлт, зулбалт, хүүхдийн бага жинтэй төрөлт, төрөлхийн гажиг зэргийг удаан задардаг органик бодисын нөлөөтэй холбон үзэж байна.

2001 онд Шведийн Стокгольм хотноо хүний эрүүл мэнд, байгаль орчныг удаан задардаг органик бохирдуулагчийн сөрөг нөлөөллөөс хамгаалах эрхэм зорилготойгоор “Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай конвенц” – ийг баталж, 100 гаруй орон үүнийг дэмжиж нэгдэн орсоны дотор Монгол Улс 2002 онд нэгдэн орсон байна.

Удаан задардаг органик бохирдуулагчдад альдрин, хлордин, ДДТ, дельдрин, эндрин, гептахлор, гексахлорбензол, мирекс, токсафен, полихлорт бифенилүүд, диоксан ба фуран зэрэг 12 нэр төрлийн бодис ордог байна. Эдгээрээс хортон шавж устгагч бодисууд болох альдрин, хлордан, дельдрин, эндрин, гексахлорбензол, мирекс, токсафен, полихлорт бифенил зэргийг үйлдвэрлэл болон хэрэглээ, импорт, экспортыг ч хориглохоор конвенцид заажээ.

Хүнсний аюулгүй байдлын чухал нэгэн хүчин зүйл болох химийн бодис, пестицидийн үлдэгдлээс үүссэн өвчний олон тохиолдол гарч байна. Тухайлбал, пестицидийн хэрэглээнээс болж жилд дунджаар 2 сая гаран хүн хордож, 42 мянган хүн амь насаа алддаг гэсэн Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын мэдээ байдаг байна. Дэлхийн хэмжээнд 6000 нэр төрлийн 130 сая тонн пестицид үйлдвэрлэгдэж, энэ нь ургац хураалтыг сүйтгэдэг 9000 төрлийн ургамлын хачиг, шавж, 50000 төрлийн ургамлын эмгэгтөрөгч, 8000 төрлийн хогийн ургамлыг устгахад зориулагддаг.

Эрдэмтдийн тооцоолсноор ургамлын шавж, хачиг нь 14%, эмгэгтөрөгчид 13%, хог ургамал 13%-иар тус тус ургацын гарцыг бууруулдаг буюу пестицид хэрэглэдэггүй байсан бол дэлхий дээрх жимсний ургац 78%, ногоо 54%, үр тариа 32%-иар гэмтэж, ургац хураалт 35-42%-иар багасах юм гэдгийг тогтоожээ.

Сүүлийн 30-аад жилд дэлхий нийтээр хүрээлэн буй орчин хүнд хоруу чанар багатай биопестицидийг өргөнөөр хэрэглэх болсон ба хэрэглээ нь жил бүр нэмэгдэж байна. Биопестицид гэдэг нь амьтан, ургамал, бичил биетэн, зарим эрдсийн бодис зэрэг байгалийн материал ашиглан гарган авсан пестицид юм.

Манай орны бэлчээр, тариалангийн талбайд нийт 4 зүйл мэрэгч, 1300 орчим зүйл шавж, 405 зүйл өвчин, 430 зүйл хог ургамал тархан хөнөөл учруулж, үр тариа, төмс, хүнсний ногооны ургацыг 20-30 %-иар бууруулж байна.

Манай улс нь нийт хүнсний бүтээгдэхүүнийхээ 70-80%-ийг импортоор авдаг бөгөөд цагаан будаа, элсэн чихэр, жимс жимсгэнэ зэрэг ургамлын гаралтай бүтээгдэхүүнийг 90-100% импортоор авч хэрэглэж байна.



Ургамал хамгааллын үндсэн арга нь хорио цээрийн арга юм. Монгол оронд гадаад хорио цээртэй 35 зүйлийн, дотоод хорио цээртэй 17 зүйлийн шавж, хачиг байдгаас 1996 онд гадаад болон дотоод хорио цээртэй 3 багт хамаарах 11 овгийн 16 зүйлийн хөнөөлт шавж, 1 зүйлийн хачгийг илрүүлэн тэмдэглэснээс 26,6% нь гадаад хорио цээртэй шавжууд илэрч байсан.

2016-2018 оны судалгаагаар 3 аж ахуй нэгжээс 9 төрлийн 25 дээжинд шинжилгээ хийхэд 3 зүйл гадаад хорио цээртэй шавж илэрсэн байна.




Импортоор орж ирж байгаа пестицидүүдийг агууламжаар нь шалгаж, нэвтрүүлэх шаардлагатай байдаг. Гэтэл нийт пестицидийн 84% нь агууламжаар, бусад нь худалдааны нэрээр орж ирж байна.

Пестицидийн хэрэглээний талаар

Олон улсын “Тогтвортой газар тариалангийн Сүлжээ” (Sustainable Agriculture Network)-ний Стандартын Хороо, Удирдах зөвлөлөөс 2011 онд “Хориглосон пестицидийн жагсаалт”-аар хүнд

Ургамал хамгааллын зориулалтаар ашиглах пестицидийн нэр төрөл 2013 – 2019 он



хортой, хавдар үүсгэдэг ацетат, альдрин, альфа гексахлорциклогексан, карбофуран, хлордан, карбарил, хүнцэл, мөнгөн ус болон кадьюми агуулсан нэгдлүүд, DDT, дельдрин, диметинамид, фенвалерат, эльдрин, флюорацинамид, гептахлор, пента болон гексахлорбензон, линдан, метамидофос, паратион, мирекс, паракуат, перметрин, полихл орбифенил, тиазофос, винилхлорид, тиодикарб, пентахлорфенол болон тэдгээрийн давсууд, оксидометонметил зэрэг 100-аад нэр төрлийн пестицид хэрэглэхийг хориглосон байна.

Тариаланчид, аж ахуйнуудын хувьд пестицид хэрэглээний талаарх мэдлэг дутмаг, хяналт сул байна. Шавжийн эсрэг хэрэглэдэг бодистой андуурч гербицид цацсанаас 100 га талбайгаа уринш болгож байсан тохиолдол Сэлэнгэ аймгийн Түшиг, ариутгасан үрээр тарьсан рапсны таримал идэж олон тооны мал үхсэн тохиолдол Хушаат, хүлэмжинд пестицид хэрэглэж байгаа тохиолдол Баянгол суманд гарсан. Мөн хүмүүс хэрэглэж буй бодисынхоо нэрийг мэдэхгүй, дам хүнээс авч хэрэглэх, пестицидийн тун нормыг баримтлахгүй, дур мэдэн хэрэглэх явдал элбэг тохиолдож байна.

Манай орны хамгийн их ургамлын гаралтай бүтээгдэхүүн нэвтэрдэг Замын-Үүд дэхь Хилийн мэргэжлийн хяналтын лаборатори 2018 онд Ургамлын хорио цээрийн чиглэлээр 6059 сорьцонд 18103 үзүүлэлтээр шинжилгээ хийхэд 62 үзүүлэлт хангалтгүй, Сэлэнгэ аймгийн Мэргэжлийн хяналтын лаборатори Хөтөл-Тариалан эрхлэлтийг дэмжих Сан, Сэлэнгэ-Тариалан эрхлэлтийг дэмжих сан, Ургамал Газар Тариалангийн ЭШ-ний хүрээлэн, Хүдэр зэрэг газруудын нийт 17 аахуйн нэгжийн 39 дээжинд 114 үзүүлэлтээр газар дээр нь шинжилгээ хийхэд 38 дээж буюу нийт дээжийн 97,4% нь хангалтгүй дүн үзүүлсэн байна.

Пестицидийн тандалт

Хөгжингүй орнуудад Пестицидийн тандалтын хөтөлбөр, Пестицидийн менежментийг үр дүнтэй хэрэгжүүлдэг. Тухайлбал, Европын Холбооны хувьд бүх гишүүн орнууд дагаж мөрдөх нэгдсэн хөтөлбөртэй ба жил бүр 400 төрлийн пестицидийн үлдэгдлийг төрөл бүрийн жимс, хүнсний нарийн ногоонд шинжилж, мэдээллийн нэгдсэн санд бүртгэж, үр дүнг гишүүн орнууддаа мэдээлж тайлагнадаг байна. Хөгжингүй орнуудад хэрэгжүүлж байгаа дээрх хөтөлбөрүүдийн үр дүнг эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээ хийх, үлдэгдлийн дээд түвшин (ҮДТ)-г тогтооход ашигладаг. Үлдэгдлийн дээд түвшин гэдэг нь олон улсад хэрэглэхийг зөвшөөрсөн, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэггүй пестицидийн хүнсэнд байх ёстой үлдэгдлийн хамгийн өндөр түвшин юм.

Харин хөгжиж буй орнуудад лабораторийн чадавх, хүрээлэн буй орчин, хүнсэн дэх үлдэгдлийн түвшинг хянах болон тандалт хийх мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай байдгаас Пестицидийн тандалт, менежментийг хангалттай сайн хэрэгжүүлж чаддаггүй байна. 2011 онд Шинжээчдийн Хорооны Тандалтын хөтөлбөрийн тайлангаар Европын Холбооны нутаг дэвсгэр дээр борлуулагдаж буй алим, лийр, жүрж, усан үзэм, гүзээлзгэнэ, нимбэг, хальстай шош, лууван, өргөст хэмх, бууцай, сонгино, төмс, цоохор майлз, шанцай, будаа, утсан загас, шувууны мах, элэг, сүү зэрэг 23 нэр төрлийн хүнсний 889 дээжинд тус бүр 372 пестицидийн үлдэгдэл тодорхойлоход 26 дээжинд зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн байна гэсэн дүнг танилцуулжээ.

Санал дүгнэлт

Монгол Улсын ургамал хамгааллын тухай хуулинд ургамал хамгааллын асуудлыг хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын нэгж байхаар заасан байдаг. Ургамал хамгааллын ажлыг нэгдсэн удирдлагатай болгох, мониторингийн зардлыг ХХААХҮЯ-ны сайдын төсөвт тусгах;

Хүнсний бүтээгдэхүүн их хэмжээгээр импортоор орж ирдэг хилийн боомт дээрх хүнсний хяналтын лабораторийг чадавхжуулах, хүнсний сүлжээний бүх үе шатуудад зохистой дадлыг заавал нэвтрүүлж мөрдөх;

Монгол Улсын газар тариалангийн салбарт олон улсад хэрэгжүүлдэг “Хөдөө аж ахуйн зөв дадал”, “Пестицидийн тандалтын хөтөлбөр”, “Пестицидийн нэгдсэн менежмент” зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

Импортын болон эх орны төмс, хүнсний ногоонд пестицидийн үлдэгдэл хэмжээ, хүний эрүүл мэндэд нөлөөлөх эрсдэлийг үнэлэх судалгаа шинжилгээний ажлыг орчин үеийн шаардлага хангасан багаж төхөөрөмж, олон улсын арга, аргачлалын дагуу үнэн зөв хийж, хэрэглэгчдийг шинжлэх ухааны үндэслэлтэй, нотолгоонд суурилсан мэдээллээр хангах зайлшгүй шаардлагатай байна.

Док, Проф. Н.ЭНХБОЛД,

Док, дэд Проф Ч.МЯГМАР

Ургамал Хамгааллын Эрдэм Шинжилгээний Хүрээлэн



МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН ДАЛБАА. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА. MNS 6262:2011 СТАНДАРТАД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛЛАА

Аливаа улс орны төрийн далбааг стандартын шаардлагын дагуу хийх нь буруу зөрүү хийхгүй байх нөхцөл бүрдэх бөгөөд тусгаар тогтнолоо хүндэтгэн үзэж байгаагийн нэг томоохон илэрхийлэл юм. Үүнтэй уялдан гадаад орнуудаас манай төрийн далбаанд тавих шаардлагыг тодруулж, стандарт баримт бичгээ ирүүлэхийг хүсэлт болгодог.

Сүүлийн жилүүдэд нийгмийн ухамсар дээшилж, эх оронч үзлийг дэмжих үүднээс манай иргэд баяр ёслол болон бусад үйл ажиллагаанд төрийн далбаагаа хэрэглэх нь ихсэж байна. Гэвч нь Монгол Улсын эрх чөлөө, тусгаар тогтнолын бэлгэ тэмдэг болсон далбааг алдаатай хэвлэх, оёх, зурах болон алдаатай далбааг цахим хуудсанд байршуулснаас буруу зөрүү хийсэн далбаагаар эх оронч үзлээ илэрхийлэх болж, төрийн далбаандаа хүндэтгэлтэй хандах асуудал орхигдож байна. Жишээ нь: галын дөлийн зураглал нь хонхон цэцэг болсон, хос загас нь нар буруу тийшээ эргэсэн, хөх цэнхэр өнгө нь цайвар цэнхэр, улаан өнгө нь хүрэн болсон, соёмбын багана нь өргөн, нарийн болсон, ишний талд цагаан өнгийн оруулга оруулсан гэх мэт алдаатай хувилбаруудыг хэрэглэсээр байгааг засч залруулах шаардлагатай болсон.

Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуулиудад "Монгол Улсын төрийн далбаа нь улаан хөх, улаан өнгө хосолсон байна. Монгол Улсын төрийн далбаа нь улаан, хөх, улаан хосолсон өнгөтэй байна. "Далбааны гурав хуваасны нэгийн хэмжээтэй дундах хэсэг нь мөнх тэнгэрийн хөх, түүний хоёр тал нь мандан бадрахын бэлгэдэл улаан өнгөтэй байна. Далбааны ишин талын улаан дэвсгэрийн төв хэсэгт алтан соёмбо байрлуулна. Далбааны өргөн, урт нь 1:2-ын харьцаатай байна" гэж заасан байдаг. Энд өнгөний кодыг заагаагүйгээс далбааны өнгийг олон янзын улаан, цэнхэр өнгөөр үйлдвэрлэх нөхцөлийг бүрдүүлж байна. Мөн Үндсэн хуулинд хавсаргасан төрийн далбааны соёмбын тэгийг зургаар тодорхой үзүүлсэн боловч харьцааг тодорхой тайлбарласан нарийн тайлбар хэрэгтэй байна.

Түүнчлэн чанаргүй материалаар хийсэн далбаа бороонд норж өнгөө алдан, нар, салхинд амархан гандсанаас өнгөнд өөрчлөлт ордог зэргийг харгалзан төрийн далбааны стандартыг тогтоож мөрдүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Стандартын төслийг боловсруулахдаа ОУ-ын Өнгөний нийгэмлэгээс гаргасан өнгөний код, ОХУ болон АНУ-ын холбогдох стандартыг үндэслэл болгосон.

ЗОРИЛГО

- Монгол Улсын төрийн далбааг олон улсын өнгөний кодын дагуу коджуулах;
- Төрийн далбаан дахь соёмбын харьцааг тодорхой болгох;
- Монгол Улсын төрийн далбаа хийх даавууны чанарын шаардлагыг тогтоох.

АЧ ХОЛБОГДОЛ

- Төрийн далбааны стандартыг тогтоосноор: Монгол Улсын тусгаар тогтнолын бэлгэ тэмдэг төрийн далбаандаа хүндэтгэлтэй хандаж сурах, түүхт ёс, түүхэн уламжлалаа нандигнан өвлөх;
- Төрийн далбааг олон улсын өнгөний кодоод нийцүүлж коджуулснаар төрийн далбааны өнгөний талаар дотоод, гадаадад нэгдсэн ойлголттой болох;
- Монгол Улсын төрийн далбааг гутаан доромжлох, уламжлалыг нь алдуулах, санаатай болон санамсаргүйгээр алдаатай хийх явдлыг зогсоох, алдаатай төрийн далбааг хэрэглэхгүй байх зэрэг томоохон ач холбогдолтой болох юм.

Иймд 2011 онд батлагдсан MNS 6262 стандартад төрийн далбааны өнгөнд тавигдах шаардлагыг CMYK өнгөний кодоор стандартчилсан бөгөөд дээрх кодоор үйлдсэн төрийн далбаа өөр өөр өнгөөр дүрслэгдэх, хэвлэгдэх зэргээр төрийн үйл ажиллагаанд тавигддаг зохих шаардлагыг хангахгүй байх тул төрийн далбааны өнгөнд тавигдах шаардлагыг олон улсад өргөн хэрэглэгддэг өнгөний нарийвчлал сайтай PANTONE өнгөний кодоор стандартчилах нь зүйтэй гэсэн саналыг үндэслэсэн.

Тус стандартыг Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2018 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 14 дүгээр тогтоолоор нийт 4 хэсэгт нэмэлт өөрчлөлт оруулан баталсан.

Нэмэлт өөрчлөлт оруулсан стандартад дараах байдлаар өнгөний кодыг заасан.

Scheme	Blue	Yellow	Red
Pantone	19-4150 tpx	13-0758 tpx	18-1763 tpx
CMYK	89-45-0-38	0-18-100-0	0-86-76-22
RGB	17-88-159	255-209-0	200-29-49

СТУБГ-ын мэргэжилтэн Ц.Оюунгэрэл



МОРЬ УНААЧ ХҮҮХДИЙН ХАМГААЛАЛТЫН ХУВЦАС, МОРИНЫ ХЭРЭГСЭЛД ТАВИХ ШААРДЛАГА. MNS 6264:2018 СТАНДАРТЫГ ШИНЭЧЛЭН БАТАЛЛАА

2010 оны 10 дугаар сард ЮНЕСКО-ийн Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн төлөөллийн жагсаалтад Монголын уламжлалт баяр болох “Наадам” бүртгэгдсэн. Тухайн жагсаалтад бүртгүүлснээр эрийн гурван наадмын нэг болох хурдан морины уралдаан нь бөх, сур харвааны нэгэн адил монголчуудын соёлын өв мөн болохыг олон улсын хамтын нийгэмлэгийн хувьд хүлээн зөвшөөрүүлсэн явдал болсон.

УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалаар “Үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалж хөгжүүлэх нь монгол үндэстний оршин тогтнохын үндэс, амин чухал дархлаа мөн” гэж тунхагласан. Иймээс ч төрийн бодлогын хувьд хурдан морины уралдаан нь төрийн хамгаалалтад байх үндэсний соёлын өвд багтах бөгөөд үндэсний наадам, уламжлалт тоглоом, наадгайн зан үйлийн хэлбэрийнхээ хувьд соёлын биет бус өв юм. Харин эдгээр соёлын өвийг хамгаалахдаа тухайн салбарын олон улсын гэрээ, конвенцоор хүний эрхийн тухай олон улсын эрх зүйн одоо мөрдөгдөж буй баримт бичгийг иш үндэс болгон хандах ёстойг тэмдэглэсэн байдаг. Өөрөөр хэлбэл хурдан морины уралдаан нь соёлын өв гэж үзэх боловч хүний эрх, тэр дундаа хүүхдийн эрхийн асуудлыг үндсэн шалгуурын нэг болгон авч үзэх зайлшгүй шаардлагатай юм.

Хурдан морины унаач хүүхдийн бэртэл, гэмтлийн бүртгэл мэдээлэлд дүн шинжилгээ хийж, холбогдох эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдтэй судалгааны үндсэн дээр хаврын хурдан морины уралдаанд оролцож буй хүүхдийн эрүүл мэндийн эрсдэлийг бий болгож байгаа хүчин зүйлүүдийг дараах байдлаар тодорхойлсон байна.

Үүнд хурдан морины уралдаанч хүүхдийн нас, цаг агаар, уур амьсгалын нөхцөл байдал, дуу, уралдааны зохион байгуулалт, уяачдын туршлага,

чадварын асуудал зэргийг нэрлэсэн бөгөөд Эрүүл мэндийн байгууллага дээр хийгдсэн клиник бодит судалгаа болон бэртэл гэмтэлд хийгдсэн дүн шинжилгээгээр хурдан морины унаач хүүхдэд толгой болон мөчдийн гэмтэл, ясны хугаралт, хөлдөлт, осголт, амьсгалын замын өвчин, дотор эрхтэний доржилт, өвчлөлт, нүдний эвэрлэг бүрхүүлийн гэмтэл зэрэг бэртэл гэмтэл авдаг байна.

Иймээс Монгол улсын Засгийн газар, Шадар сайдаас онцгой анхаарч Стандарт хэмжилзүйн газарт үүрэг болгосны дагуу Стандартчиллын үндэсний зөвлөлөөс 2011 онд шинээр батлан мөрдөж байсан “MNS 6264:2018 Үндэсний морин уралдааны морь унаач хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавих шаардлагын стандартыг 2018 онд шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг Стандарт, хэмжил зүйн газрын даргын тушаалаар байгуулж морь унаач хүүхдийн осол гэмтлийн статистик мэдээ зэргийг нарийвчлан судлаж, орон нутгийн засаг захиргааны байгууллага, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагаас асуумж, судалгаа авч, тэдгээрийн гаргасан санал, зөвлөгөөг үндэслэн СХЗГ-ын даргын тушаалаар “MNS 6264:2018 Үндэсний морин уралдааны морь унаач хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавих шаардлага” стандарт шинэчлэн баталлаа.

Энэхүү стандартаар үндэсний морин уралдааны морь унаач хүүхдийн уралдаан болон бэлтгэл сургуулилын үед өмсөх хамгаалалтын хувцас, морины хэрэгсэл тухайлбал хүүхэд бэртэж гэмтэхээс урьдчилан сэргийлэх зориулалт бүхий малгай, юүдэн, хантааз, бээлий, өвдгөвч, тохойвч, шилбэ, шуу, гутал, мөн уралдааны морины хэрэгсэл болох эмээл, дөрөө, хазаар, ташуурын хэмжээ зэрэг үзүүлэлт, шаардлагуудыг тодорхой тусгаж өгсөн.

СТУБГ-ын ахлах мэтгэжилтэн Н.Батжаргал

